# ИРГЭДИЙН ТӨСӨВ 2022



МОНГОЛ УЛСЫН
НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ

**Монгол Улсын Сангийн яамны санаачилгаар, Европын холбооны буцалтгүй тусламжаар Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Монгол Улсад засаглалын бэхжүүлэх төслийн хүрээнд энэхүү товхимлыг бэлтгэн гаргав.**

Уг товхимлыг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд "**Иргэдийн төсөв-2022, Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл**", **Сангийн яам** хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу. Санал хүсэлт болон агуулгатай холбоотой лавлах зүйл байвал ***tusuv@mof.gov.mn*** цахим шууданд ирүүлнэ үү.

# МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт иргэн Танд энэ өдрийн мэндийг хүргэе!

Сангийн яамны санаачилгаар 2018 оноос эхлэн Монгол Улсын төсвийн мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй, ойлгомжтой байдлаар дүрслэн харуулсан “Иргэдийн төсөв” эмхэтгэлийг жил бүр бэлтгэн хүргэж байна.

Тус эмхэтгэл нь иргэдэд төсвийн тухай мэдлэгээ дээшлүүлэх, төсөв боловсруулах үйл явц дахь өөрсдийн оролцоог нэмэгдүүлэх, цаашлаад төлсөн татварынхаа төгрөг нэг бүрийг хэрхэн зарцуулж байгаад хяналт тавих боломжийг бүрдүүлэх өндөр ач холбогдолтой юм.

Коронавируст халдварын цар тахал 2020 оноос дэлхий даяар эрчимтэй дэгдэж, эдийн засаг, нийгэмд урьдчилан тооцоолох боломжгүй томоохон эрсдэл учруулсан хүндхэн цаг үеийг бид туулж байна.

Аюулт цар тахлын нөлөөгөөр уналтад орсон эдийн засаг, бизнесүүдийг дэмжих, иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах хариуцлагатай үед миний бие Сангийн сайдын албыг хүлээн авсан билээ. Иймд ирэх жилүүдэд эдийн засгийг дахин сэргээх их үйлсэд шуурхайлан орж, улс орноо хөгжлийн дараагийн шатанд гаргах арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх сорилт хүлээж байна.

Ирэх 2022 онд цар тахлын дараах улс орны эдийн засгийг эрчимтэй сэргээх зорилтыг хангахад чиглэсэн “ХӨДӨЛМӨР, БҮТЭЭМЖ, ӨСӨЛТ”-ийг дэмжих төсвийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх шинэчлэлийн багц стратеги бүхий төсвийн төслийг боловсруулан танилцуулж байгааг хүлээн авна уу.

**Хүндэтгэсэн,**
**Болдын ЖАВХЛАН**



**Монгол Улсын Их Хурлын гишүүн,**
**Сангийн сайд**

# ИРГЭДИЙН ТӨСӨВ-2022
## МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

# АГУУЛГА


5 **2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСЛИЙН БОДЛОГО, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**
- Төсвийн бодлого
- Макро эдийн засгийн үзүүлэлт
- Нэгдсэн төсвийн үзүүлэлт

10 **ТӨСВИЙН ОРЛОГО**
- Төсвийн орлого, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлс
- Төсвийн орлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Нэгдсэн төсвийн нийт орлого

15 **ТӨСВИЙН ЗАРЛАГА**
- Төсвийн урсгал зардлын төсөлд баримталсан бодлого
- Төсвийн шинэчлэл
- Нэгдсэн төсвийн нийт зарлага
- Салбарын онцлогууд
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт
- Гадаадын зээл тусламж
- Орон нутгийн төсөв
- Нийгмийн даатгалын сангийн төсөв
- Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв
- Ирээдүйн өв сангийн төсөв

49 **ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР**
- Засгийн газрын өр

52 **НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ**
- Төсвийн бүрдэл хуваарилалт
- Төсөв боловсруулах, батлах цаглабар
- Товчилсон үгсийн жагсаалт
- Санал хүсэлтийн хэсэг

# БҮЛЭГ 1

## 2022 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСЛИЙН БОДЛОГО, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

# ТӨСВИЙН БОДЛОГО - 2022

# "ХӨДӨЛМӨР, БҮТЭЭМЖ, ӨСӨЛТ"

Ирэх 2022 оны төсвийн жилд *Алсын хараа 2050, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг* үе шаттай хэрэгжүүлэхэд чиглэсэн **ХӨДӨЛМӨР, БҮТЭЭМЖ, ӨСӨЛТ**-ийг дэмжих төсвийн бодлогын хүрээнд дараах багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

### 1. ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ

Хөгжлийн төслүүдийг эхлүүлэх, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих замаар **ЭДИЙН ЗАСГИЙГ СЭРГЭЭХ** шинэчлэл хийнэ.



### 2. ТӨРИЙН ӨМЧИЙН ШИНЭЧЛЭЛ

Төрийн өмчит компаниудын **ҮР АШИГ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА, ӨГӨӨЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ** шинэчлэл хийнэ.

### 3. ХУРИМТЛАЛТАЙ ХҮҮХЭД

Байгалийн баялгийн хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүгийн баталгаатай **"ХУРИМТЛАЛТАЙ ХҮҮХЭД"** хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### 4. ХАЛАМЖААС ХӨДӨЛМӨРТ

Хөдөлмөр эрхлэх чадвартай, орлого багатай иргэдийг халамжаар бус ажил эрхлэлтээр дэмжихэд чиглэсэн **ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ** шилжих шинэчлэл хийнэ.

## 5. ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж **СТАНДАРТ-ЧАНАР-ӨРСӨЛДӨӨН**-д суурилсан үйлчилгээг төр худалдан авдаг тогтолцоонд шилжинэ.

## 6. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ

Эрүүл мэндийн  салбарт энэ онд хэрэгжүүлж эхэлсэн шинэчлэлийг эрчимжүүлж **ИРГЭДЭЭ ЖИЛ БҮР УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГТ** хамруулна.



## 7. ХЭМНЭЛТИЙН ГОРИМД ШИЛЖИХ

Төр хэмнэлтийн бодлого хэрэгжүүлж, зардлыг оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр **ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ҮР АШГИЙГ САЙЖРУУЛНА.**

## 8. ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ

Хөрөнгө оруулалтын аргачлал, цахим системийн дагуу үнэлгээ хийгдсэн **ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮДИЙГ** нэн тэргүүнд хэрэгжүүлнэ.

## 9. ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛНА

Улаанбаатар хотын авто замын **ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХАД** шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэнэ.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын эдийн засаг 2022-2024 онуудад жилд дунджаар 5.0 орчим хувь өсөх төлөвтэй байна.

*"Эдийн засаг өсөлттэй, макро үзүүлэлтүүд тогтвортой байх нь иргэдийн амьжиргаа дээшлэх, хөгжилд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх боломж олгодог.*



## ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Тухайн нутаг дэвсгэрт дотоод, гадаадын аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн 1 жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт бараа бүтээгдэхүүн.

*/их наяд төгрөг/*




## ГАДААД ХУДАЛДАА

**Экспорт**
Монгол улсын нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа бараа, үйлчилгээ

**Импорт**
Хилийн чанадаас Монгол улсын нутаг дэвсгэрт оруулж байгаа бараа, үйлчилгээ

*/тэрбум ам.доллар/*




## ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ

Инфляц буюу үнийн өсөлтийн нөлөөллийг тооцсон ДНБ-ий өсөлт

*/хувь/*




## ИНФЛЯЦ

Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өсөлт

*/хувь/*




**Хүлээгдэж буй гүйцэтгэл*
***Төсөөлөл*

# НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

**2022 ОНЫ ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ**

**-2,387.1 тэрбум₮** (ДНБ-ий -5.1%)

Тэнцвэржүүлсэн орлого

Нийт зардал

> *Төсвийн оновчтой бодлого баримталж, сахилга батыг сахисны үр дүнд төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь жил ирэх тусам буурч байна.*



**ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО** | **15,771.7 тэрбум₮**




1. **Татварын орлого** 13,941.3 тэрбум₮
2. **Татварын бус орлого** 1,531.9 тэрбум₮
3. **Тусламжийн орлого** 298.5 тэрбум₮

**НИЙТ ЗАРДАЛ** | **18,158.8 тэрбум₮**

1. **Урсгал зардал** 13,307.3 тэрбум₮
2. **Хөрөнгийн зардал** 5,116.1 тэрбум₮
3. **Эргэж төлөгдөх цэвэр зээл** -264.6 тэрбум₮



# БҮЛЭГ 2

## НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО

# ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БОЛОН ТҮҮНД НӨЛӨӨЛЖ БАЙГАА ХҮЧИН ЗҮЙЛС

Ирэх онд гадаад худалдааг хөнгөвчлөх, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглалын шинэчлэл хийх, татвар, гаалийн шинэчлэлийг үргэлжлүүлэх зэргээр нэгдсэн төсвийн нийт орлогыг 2021 оны түвшнээс нэмэгдүүлж **16.4 их наяд төгрөг** хүргэнэ.









** Монгол банканд тушаах алтны хэмжээ*

## УУЛ УУРХАЙН ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨЛӨВ :

### ЗЭС
- Хэмжээ: **1.2** сая тн
- Үнэ: **8,915.6**ам.доллар/тн

### НҮҮРС
- Хэмжээ: **36.7** сая тн
- Үнэ: **132.1** ам.доллар/тн

### АЛТ*
- Хэмжээ: **20** тн
- Үнэ: **1,821** ам.доллар/унц



# ТӨСВИЙН ОРЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

## 1. ГАДААД ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ

Хил дээрх хяналт шалгалтын давхардлыг арилган, бүрдүүлэх бичиг баримтыг цөөлж, цахим хяналтын систем нэвтрүүлнэ.

**БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ШИНЭЧЛЭЛ**

Санхүүгийн эрсдэл өндөр, төр оролцох шаардлагагүй компаниудыг нэгтгэх болон татан буулгах, харин төрийн оролцоо шаардлагатай, санхүүгийн хувьд үр ашигтай байх боломжтой компаниудыг Хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй хувьцаат компани болгоно.



*Гадаад худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд бизнес эрхлэх таатай нөхцөл бүрдэж, хил орчмын худалдааны үзүүлэлтүүд сайжирна.*

### ЖИШЭЭ: НООС ЭКСПОРТЛОХ ҮЙЛ ЯВЦ, ЗАРЦУУЛАХ ЦАГ

А. Бүрдүүлэлтэд шаардагдах бичиг баримт:

- Гаалийн экспортын мэдүүлэг/декларац
- Гадаад худалдааны гэрээ/нэхэмжлэл
- Нэгдсэн лабораторийн дүгнэлт/ОУ-ын сертификат
- Ачааны манифест

**168 цаг!** → **21 цаг**

Б. Экспортын хяналт шалгалт:

- Гаалийн хяналтын байцаагч / рентген шалгалт/

**134 цаг!** → **12 цаг**



## 2.ТӨРИЙН ӨМЧИЙН КОМПАНИЙН ШИНЭЧЛЭЛ

Төрийн өмчит компаниудын **ашигт ажиллагаа, засаглал, ил тод байдал, хариуцлагыг сайжруулж төсөвт төвлөрүүлэх өгөөжийг нэмэгдүүлнэ.**

### НОГДОЛ АШГИЙН БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛ

Ногдол ашиг тооцох зохицуулалтыг цэвэр ашгийн 50 хувь, эсхүл төрд ногдох эздийн өмчийн 1 хувьтай тэнцэх дүнгийн аль өндөр хэмжээгээр тооцдог болсноор төрийн өмчит компанийн зардлын сахилга батыг сайжруулж төсөвт оруулах өгөөжийг нэмэгдүүлнэ.

### ЗАСАГЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ

Компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, ил тод байдал, гүйцэтгэх удирдлагын шаардлагыг олон улсын стандартад нийцүүлж хариуцлагыг нэмэгдүүлнэ.

## 3. ТАТВАРЫН СУУРИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ

Татварын үйлчилгээ, татвар төлөлтийг цахимжуулж, хялбаршуулах, хүний хамаарлыг бууруулах, татварын суурийг хамгаалах татварын шинэчлэлийг үргэлжлүүлнэ.

### 1. ТАТВАРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН АШИГЛАЛТЫГ ДЭМЖИХ

Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллийг цахимжуулж татвар төлөгчид татварын тооцоолол хийх, татварын болзошгүй өр төлбөрөөс урьдчилан сэргийлэх, татварын эрсдэлийн талаар мэдэгдэх зэрэг дэмжлэг үзүүлнэ.

### 2. “E-BARIMT”-ИЙН СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

Иргэд татварын үйлчилгээг гар утсаа ашиглан нэг цонхоор авах, албан татвар, төлбөр, хураамжаа түргэн шуурхай, хялбараар төлөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор олгохоор “E-barimt” системийг үргэлжлүүлэн хөгжүүлнэ.

### 3. ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫГ МӨРДӨХ

Татварын ил тод байдал, мэдээлэл солилцооны олон улсын форумын гишүүн орны хувьд татвараас зайлсхийхийн эсрэг болон мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагааны олон улсын стандартыг татварын үйл ажиллагаанд үргэлжлүүлэн мөрдөнө.

# НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО
## ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

/тэрбум төгрөг/

Уул уурхайн орлого 4,261.9

Эдийн засгийн өсөлтөөр 6,147.4

Импортын орлого 4,175.4

Татварын бус орлого 1,830.4

**МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО**
16,415.1 тэрбум₮ ▲ 19.5%

**Тогтворжуулалтын сан**
643.4 тэрбум₮ ▲ 5.0%

**ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО**
15,771.7 тэрбум₮ ▲ 30.8%

▼▲ 2021 оноос өөрчлөлт

| ТАТВАРЫН ОРЛОГО | | |
|---|---|---|
| Хувь хүний орлогын албан татвар | 1,149.2 тэрбум₮ | ▲ 14.6% |
| ААН-ийн орлогын албан татвар* | 1,776.8 тэрбум₮ | ▼ 11.6% |
| Нийгмийн даатгалын орлого | 2,987.5 тэрбум₮ | ▲ 57.5% |
| Хөрөнгийн албан татвар | 213.4 тэрбум₮ | ▲ 21.5% |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 3,441.8 тэрбум₮ | ▲ 22.7% |
| Онцгой албан татвар | 1,132.2 тэрбум₮ | ▲ 28.8% |
| Тусгай зориулалтын орлого | 17.2 тэрбум₮ | ▲ 14.7% |
| Гаалийн албан татвар | 1,081.9 тэрбум₮ | ▲ 15.7% |
| Бусад татвар | 2,141.3 тэрбум₮ | ▲ 136% |

| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | |
|---|---|---|
| Нийтлэг татварын бус орлого | 1,531.7 тэрбум₮ | ▲ 19.7% |
| Хөрөнгийн орлого | 170.5 тэрбум₮ | ▼ 57.4% |
| Тусламжийн орлого | 298.5 тэрбум₮ | ▲ 98.6% |

*Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлогоос тодорхой хэсгийг Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилж, үлдэх хэсэг буюу "тэнцвэржүүлсэн орлогоор" зардлыг санхүүжүүлдэг.*



**2021 онд нэг удаагийн шинжтэй 610.4 тэрбум төгрөгийн нөхөн ногдуулалтын актын төлбөрөөс хамаарч аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого өссөн.*

# БҮЛЭГ 3

## НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГА

# ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛЫН ТӨСӨЛД БАРИМТАЛСАН БОДЛОГО

1. Хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжтой зарим ажил, үйлчилгээг төр өөрөө хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж СТАНДАРТ-ЧАНАР-ӨРСӨЛДӨӨНД суурилсан үйлчилгээг төр худалдан авдаг болно..

2. Боловсрол, соёл, спорт, хүүхэд хамгааллын салбарт санхүүжилтийн шинэчлэлийг эхлүүлж, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийг эрчимжүүлнэ.

3. КОВИД-19 цар тахлын эрсдэлтэй нүүр тулж ажиллаж байгаа төрийн байгууллагаас бусад төсөвт байгууллагын тэвчиж болох урсгал зардлыг бууруулна.

4. Нийгмийн халамжийн тогтолцоог шинэчилж хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулна

5. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээ болон төрийн байгууллагын үйл ажиллагааг цахимжуулж, эдгээртэй холбоотой орон тоо, урсгал зардлыг бууруулж, иргэдийн цагийг хэмнэнэ.

6. Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг 2021 оны түвшинд хадгална.



**Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн урсгал зардлын төсөл боловсруулахад баримталсан ЗАРЧИМ:**

**Үр ашигтай байх:**

Санхүүжилтийн механизмыг нь өөрчлөх замаар нийгмийн сууръ үйлчилгээ үзүүлдэг салбаруудын төсвийг нь дахин хуваарилж, зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.

**Ил тод, шуурхай байх:**

Бүх салбарын төрийн үйлчилгээг цахимжуулж, мэдээллийг ил тод, ойлгомжтой болгоно. Иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, хүнд сурталгүй хүргэнэ.

**Хэмнэлттэй байх:**

Ухаалаг, хэмнэлттэй техник технологийн дэвшлийг ашиглан бүх шатны төсвийн байгууллагын захиргааны удирдлага, үйлчилгээ болон хөрөнгийн ашиглалтын зардлыг бууруулна.

# ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## ТӨСВИЙН ХЭМНЭЛТИЙН БОДЛОГО

Цар тахлын хүнд нөхцөлд төр өөрийн зардлаа хэмнэх, оновчтой байдлаар дахин хуваарилах, төрийн үйлчилгээг цахимжуулах зэргээр бүх шатны байгууллагуудыг хэмнэлтийн горимд ажиллах үйл явцыг манлайлах нь нэн чухал юм.



Нийт
**12.1 тэрбум төгрөг**
хэмнэнэ



### 100% хэмнэх зардлууд

- Тавилга
- Зочин төлөөлөгч хүлээж авах
- Гадаад томилолт
- Ном, хэвлэл
- Яамдын тээвэр, шатахуун
- Сургалт, семинар
- Уралдаан тэмцээн зохион байгуулах

### 50% хэмнэх зардлууд

- Дотоод томилолт
- Бичиг хэрэг

Эрүүл мэнд, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль болон төрийн тусгай чиг үүргийн байгууллагууд үүнд **ХАМААРАХГҮЙ.**

**Төрийн үйл ажиллагааны зардал хэмнэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор авч хэрэгжүүлэх бодлогын арга хэмжээнүүд:**

- Сайд нэгээс илүүгүй зөвлөх, туслахтай байх, дэд сайд, төрийн нарийн бичгийн дарга дундаа нэг туслахтай байх.
- Төрийн захиргааны байгууллагууд авто машин хэрэглэхгүй.
- Тэтгэвэрт гарсан 2 албан хаагч тутамд нэг албан хаагч шинээр ажилд авах.
- Төрийн захиргааны байгууллагын албан хаагчийг ажлын 1 өдөрт нь гэрээсээ цахимаар ажиллах горимд шилжүүлэх.
- Цэвэрлэгээ, засвар үйлчилгээ, харуул хамгаалалт, дулаан хангамж, хоол үйлдвэрлэлийг хувийн хэвшлээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.
- Албан контор шинээр барихгүй, тусгай чиг үүрэг гүйцэтгэхээс бусад байгууллага автомашин шинээр худалдан авахгүй байх.
- Бүх шатны төрийн байгууллагын сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зохион байгуулах, албан хаагчийг мэргэшүүлэх арга хэмжээг цахимаар зохион байгуулах.
- Төсвийн хөрөнгөөр кино хийхгүй, ой тэмдэглэхгүй, ном хэвлүүлэхгүй, шагнал урамшуулал өгөхгүй байх.
- Засгийн газрын агентлаг нэгээс илүүгүй дэд даргатай байх, дарга нь зөвлөхгүй ажиллах.
- Цахим гарын үсэг нэвтрүүлж банк, даатгал, нотариат, тусгай зөвшөөрөл, хөрөнгө болон эрх өмчлөх, эзэмших, ашиглах шилжүүлэх, сунгах зэрэг үйлчилгээнд ашиглах.

# ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## ИРГЭНЭЭ ДАГАСАН САНХҮҮЖИЛТ



*Үйлчилгээ үзүүлэгч байгууллагад төсвийн эрх мэдлийг хариуцлагын хамт олгосноор үр дүнд суурилсан, иргэнээ дагасан санхүүжилтийн тогтолцоо руу шилжиж байна.*




- Үйлчилгээг бодитой, иж бүрэн, хувийн хэвшлийн сонирхлыг татахуйц-өрсөлдөөн бий болохуйц тарифаар тооцох.
- Байгууллагын төсвийг илүү үр ашигтай зарцуулахад чиглэсэн менежмент хийх боломж олгох (бүтцийн өөрчлөлт хийх, үйлчилгээг өөрчлөх, орон тоогоо өөрөө тогтоох г.м).
- Зөв менежмент, чанартай үйлчилгээний үр дүнд төсөв нэмэгдсэнээр ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгаа одоо байгаа түвшнээс сайжруулах боломжтой.

# ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ



*Хувийн хэвшил гүйцэтгэх боломжтой чиг үүргийг төр хэрэгжүүлдэг байдлаас татгалзаж чанар, үр дүнд суурилсан үйлчилгээг* ***хувийн хэвшлээс төр худалдан авдаг тогтолцоо****нд үе шаттай шилжинэ.*



**Тус шинэчлэлийг 2022 оноос үе шаттай хэрэгжүүлж эхэлснээр төсвөөс цалинждаг төрийн албан хаагчид:**

| Орон тоо | Цалингийн сан | → | Орон тоо | Цалингийн сан |
|---|---|---|---|---|
| 198.0 мян.хүн | 2.8 их наяд ₮ | | 73.6 мян.хүн | 1.1 их наяд ₮ |

# ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## ХАЛАМЖААС-ХӨДӨЛМӨРТ

Монгол улсын Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчин бэлтгэж, хөдөлмөрийн нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх, зорилтот бүлгийн онцлогт тохирсон хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлэхэд анхаарч байна.





### Төр зайлшгүй халамжлах шаардлагатай иргэдэд зориулсан хөтөлбөрүүд

**ДАВХАРДСАН** тэтгэмж, тусламжийг цэгцэлнэ.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг тодорхойлох тогтолцоог **ШИНЭЧИЛНЭ**.

Хамрагдах шалгуур үзүүлэлтийг **НАРИЙВЧИЛНА.**



### Хөдөлмөр эрхлэлттэй уялдуулах хөтөлбөрүүд

**ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЧАДВАРТАЙ боловч ОРЛОГОГҮЙ**-ээс болж хүнсний талон авдаг, эсхүл халамжийн бусад тусламж, хөнгөлөлт авдаг өрх, иргэнийг **ХАМРУУЛНА.**

Хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүдэд хамрагдах, хөдөлмөрийн биржид бүртгүүлж байнгын ажилд орох зэрэг **НӨХЦӨЛ ТАВИНА.**



# ТӨСВИЙН ШИНЭЧЛЭЛ

## БАЯЛАГТАА ЭЗЭН МОНГОЛ-ХУРИМТЛАЛТАЙ ХҮҮХЭД

"Хүүхдийн хөгжилд зарцуулсан мөнгө хамгийн сайн хөрөнгө оруулалт болдог"

*Жеймс Хэкман*
*Нобелийн шагналт эдийн засагч*



***Ийлээс Ирээдүйн өв сангаас хүүхэд багачуудаа зориулан хуримтлал бий болгоно.***

**2021** онд **34.8** мянган хүүхэд ахлах сургууль төгссөн.

Төгсөгчдөөс **72.1%** нь их, дээд сургуульд элсэж, **6%** нь МСҮТ, ПТК-д орсон бол **20% гаруй** нь үргэлжлүүлэн суралцаагүй байна.

ЕБС төгссөн хүүхдүүдэд төрөл бүрийн санхүүгийн бэрхшээлүүд тулгардаг.

Хуримтлал бий болгосноор таны хүүхэд 18 нас хүрмэгцээ байрны урьдчилгаандаа нэмэрлэх, бизнес эхлүүлэх, боловсролдоо хөрөнгө оруулах боломж бүрдэнэ.

0-18 насны **1.2** сая хүүхэд | **САР БҮР** | **100.0** мянган₮

Шилжилтийн үе буюу 2022 оны төсвийн жилд хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчийн хүсэлтээр хуримтлалыг бэлэн мөнгө хэлбэрээр олгоно.

| Хүсэлтийн дагуу хуримтлалаас бэлэн мөнгө хэлбэрээр олгох хувь | 2022 | | 2023 | 2024 |
|---|---|---|---|---|
| | 7-р сарын 1 хүртэл | 7-р сарын 1-ээс | | |
| | 100% | 50% | 40% | 30% |

# НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА
## ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

▼▲ /2021 оноос өөрчлөлт/

**НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА**

**18,158.8 ▲ 30.9%**
**тэрбум төгрөг**

### УРСГАЛ ЗАРДАЛ
13,307.3 тэрбум₮ ▲ 32.8%

Төрийн үйл ажиллагаа болон иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг олгоход шаардагдах зардал

- Цалин хөлс 1,467.8 ▼ 44.1%
- Бараа үйлчилгээ 2,597.9 ▲ 20.4%
- Зээлийн хүү 959.3 ▲ 0.0%
- Татаас 528.9 ▲ 41.1%
- Урсгал шилжүүлэг 7,753.2 ▲ 98.8%

### ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ
5,110.6 тэрбум₮ ▲ 34.4%

Барилга барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх, зэрэг хөрөнгө оруулалтын чанартай зардлууд

- Барилга,байгууламж 3,197.4 ▲ 27.3%
- Их засвар 153.2 ▼ 2.8%
- Тоног төхөөрөмж 322.6 ▼ 19.9%
- Бусад хөрөнгө 1,434.8 ▲ 101.9%
- Стратегийн нөөц хөрөнгө 8.1 ▼ 63.8%

### ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ
-264.6 тэрбум₮ ▼ 661.4%

Нийгмийн хөгжлийг дэмжих зорилгоор төсвөөс хөнгөлөлттэй олгодог зээл

*/тэрбум төгрөг/*

- Дотоод зээл -544.6 ▼ 191.6%
- Гадаад зээл 280.0 ▲ 19.7%

**Урсгал зардал** гэдэг нь тухайн жилд иргэдэд төрийн үйлчилгээг хүртээмжтэй, тасралтгүй хүргэхэд чиглэгддэг төсвийн үйл ажиллагааны зардал юм. Харин **хөрөнгийн зардалд** улсын төсвөөр барьж гүйцэтгэх хөрөнгө оруулалтын шинж чанартай зардлууд орно.

# УЛСЫН ТӨСВИЙН ЗАРЛАГА
## ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР

*/тэрбум төгрөг/*

| УРСГАЛ ЗАРДАЛ | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | ГАДААД ЗЭЭЛ ТУСЛАМЖ | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ | НИЙТ |
|---|---|---|---|---|
| 8,125.7 | 2,588.9 | 1,682.5 | -310.1 | 12,087.0 |

| | Урсгал зардал | Хөрөнгийн зардал | Гадаад зээл тусламж | Эргэж төлөгдөх цэвэр зээл |
|---|---|---|---|---|
| Сангийн сайд | 1,922.0 | 423.0 | 1,682.5 | -306.7 |
| Боловсрол, шинжлэх ухааны сайд | 1,825.9 | 489.9 | | 10.5 |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд | 1,123.2 | 57.6 | | 20.0 |
| Эрүүл мэндийн сайд | 904.4 | 125.3 | | |
| ХЗДХ-ийн сайд | 640.7 | 66.2 | | -20.6 |
| Зам, тээврийн хөгжлийн сайд | 14.3 | 449.8 | | |
| Барилга, хот байгуулалтын сайд | 21.9 | 346.4 | | 5.0 |
| Батлан хамгаалахын сайд | 281.6 | 14.1 | | |
| Монгол Улсын Ерөнхий сайд | 182.6 | 109.8 | | |
| Соёлын сайд | 115.0 | 148.4 | | |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | 164.1 | 71.3 | | -18.3 |
| Монгол Улсын Шадар сайд | 173.9 | 27.8 | | |
| Эрчим хүчний сайд | 74.0 | 119.0 | | |
| Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | 129.3 | 29.9 | | |
| МУС, ЗГ-ын Хэрэг эрхлэх газрын дарга | 73.0 | 50.9 | | |
| Гадаад харилцааны сайд | 113.4 | 8.4 | | |
| Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга | 77.5 | 2.0 | | |
| Монгол Улсын Их Хурлын дарга | 61.6 | 2.1 | | |
| Улсын ерөнхий прокурор | 56.6 | 6.2 | | |
| Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд | 12.7 | 35.5 | | |
| Авилгатай тэмцэх газрын дарга | 32.7 | 1.3 | | |
| Монгол Улсын Ерөнхий аудитор | 24.7 | 1.5 | | |
| Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга | 21.5 | 0.4 | | |
| Үндэсний статистикийн хорооны дарга | 15.6 | 2.2 | | |
| ЦАУЗБ улсын комиссын дарга | 15.3 | | | |
| ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга | 9.7 | | | |
| Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч | 9.6 | | | |
| Сонгуулийн ерөнхий хорооны дарга | 9.0 | | | |
| Санхүүгийн зохицуулах хорооны дарга | 6.6 | | | |
| Хөгжлийн сайд | 4.4 | | | |
| МУ-ын Үндсэн хуулийн цэцийн дарга | 2.8 | | | |
| Төрийн албаны зөвлөлийн дарга | 2.6 | | | |
| Цахим хөгжил, харилцаа холбооны сайд | 1.9 | | | |
| Хүний эрхийн Үндэсний комиссын дарга | 1.3 | | | |

# ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГУУД



Монгол Улсын 2022 оны төсвийн жилд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 5,213.3 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 90.0 хувь буюу 4,690.4 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 10.0 хувь буюу 522.9 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

▼▲ *2021 оноос өөрчлөлт* — */тэрбум төгрөг/*

| Яам | Сан | Дүн | Өөрчлөлт | % |
|---|---|---|---|---|
| Боловсрол, шинжлэх ухааны яам | Боловсролын зээлийн сан | 79.4 | ▲ | 47% |
| | Шинжлэх ухаан, технологийн сан | 13.1 | ▲ | 143% |
| Байгаль орчин, аялал жуулчлалын яам | Байгаль орчин, уур амьсгалын сан | 0.8 | ▼ | 20% |
| Соёлын яам | Соёл, урлагийг дэмжих сан | 2.0 | ▲ | 11% |
| Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам | Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан | 50.0 | = | 0% |
| Сангийн яам | Засгийн газрын нөөц сан | 80.0 | ▼ | 20% |
| | Төсвийн тогтворжуулалтын сан | 643.4 | ▲ | 5% |
| Батлан хамгаалах яам | Зэвсэгт хүчний хөгжлийн сан | 35.0 | = | 0% |
| Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан | 84.3 | ▲ | 120% |
| | Нийгмийн даатгалын сан | 2,718.6 | ▲ | 6% |
| | Нийгмийн халамжийн сан | 490.4 | ▼ | 84% |
| Гадаад харилцааны яам | Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан | 0.2 | = | 0% |
| Эрүүл мэндийн яам | Эрүүл мэндийг дэмжих сан | 3.0 | = | 0% |
| | Эрүүл мэндийн даатгалын сан | 1,481.4 | ▲ | 22% |
| Хууль зүй, дотоод хэргийн яам | Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан | 0.6 | = | 0% |
| Засгийн газрын хэрэг эрхлэх газар | Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан | 4.1 | ▲ | 5% |
| Зам, тээврийн хөгжлийн яам | Улсын авто замын сан | 75.0 | ▲ | 36% |

# НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

Халамжийн сангаас дараах тэтгэмжүүдийг олгодог бөгөөд нийт зарлага нь 2022 онд **490.4 тэрбум төгрөг** байхаар тооцсон.

| Халамжийн сангаас олгогдох тэтгэмжүүд | 2022 төсөл<br>*/тэрбум төгрөг/* |
|---|---|
| **Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж** | ***Ирээдүйн өв сангаас санхүүжнэ*** |
| **Халамжийн тэтгэвэр** | 119.5 |
| **Цалинтай ээж** | 123.0 |
| **Асаргааны тэтгэмж** | 59.4 |
| **Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг** | 33.2 |
| **Халамжийн бусад хөнгөлөлт** | 2.8 |
| **Алдарт эхийн тэтгэмж** | 31.3 |
| **Амьжиргаа дэмжих тусламж** | 45.3 |
| **Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт** | 26.0 |
| **Насны хишиг** | 25.4 |
| **Жирэмсэн эхийн тэтгэмж** | 11.3 |
| **Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж** | 9.8 |
| **Олон нийтийн оролцоо түшиглэсэн халамжийн үйлчилгээ** | 2.7 |
| **Асрамжийн үйлчилгээ** | 0.6 |

**Ирэх онд Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг Ирээдүйн өв сангаас санхүүжүүлж халамжийн тогтолцооноос тусгаарлана. Ингэснээр нийгмийн халамжийн тогтолцоогоор дамжуулан олгодог хүүхдийн мөнгөн тэтгэмжийг уул уурхайн баялгийн өгөөжид суурилсан "Хуримтлалтай хүүхэд" хөтөлбөр хэлбэрээр хэрэгжүүлнэ.**



# САЛБАРЫН ОНЦЛОГУУД

## ЭРҮҮЛ МЭНД

1. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.
2. Коронавирусын оношилгоо, эмчилгээ, шинжилгээний зардлыг үргэлжлүүлэн санхүүжүүлнэ.
3. Эрүүл мэндийн салбарын ажиллагчдын нийгмийн баталгааг хангана.
4. Эрүүл мэндийн байгууллагуудын засаглалыг сайжруулна.
5. Иргэн бүрийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

**Эрүүл мэндийн салбарын тогтвортой хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд:**

*Суурь түвшин (2014 он)* — *Одоогийн түвшин (2020 он)* — *Зорилтот түвшин (2030 он)*



# САЛБАРЫН ОНЦЛОГУУД
## БОЛОВСРОЛ

*Хүүхэд бүрд чанартай боловсролыг тэгш олгох боломжийг бүрдүүлсэн, сургалтын чанар, үр дүнгийн гүйцэтгэлийг урамшуулж, чадварлаг багшийг дэмжсэн, ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжоор хангасан боловсролын санхүүжилтийн цогц шинэчлэлийг хэрэгжүүлнэ.*



### ЧАНАР, ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ



### СУРГАЛТЫН ЧАНАРТ СУУРИЛСАН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫГ ОЛГОХ

Сурлагын **АХИЦ ДЭВШЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ** тогтолцоог бий болгоно. **СУРЛАГЫН АМЖИЛТААР** багшийн ажлыг үнэлж, **ТОХИРСОН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫГ** олгоно.

### ЕБС, МСҮТ-ИЙГ ХАГАС БИЕ ДААСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖҮҮЛЭХ

**ХАРИУЦЛАГЫГ САНХҮҮГИЙН ЭРХ МЭДЭЛТЭЙ НЬ ХАМТ** тухайн байгууллагад нь олгоно. Эцэг эх, ажилчдын тэгш оролцоог хангасан **ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО** бий болгоно.

### ХУВЬСАХ ЗАРДЛЫН АРГАЧЛАЛЫГ ШИНЭЧЛЭХ

**БОДИТ ӨРТӨГТ СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТ ОЛГОНО**.

### СУРГУУЛИЙН БҮТЭЦ, БАЙРШИЛ, ХЭВ ШИНЖИЙН ОНОВЧТОЙ ХУВИЛБАРЫГ ТОГТООХ

Сумдын сургуулийн бүтэц, хэв шинж, байршлыг **ДАХИН ЗОХИОН БАЙГУУЛНА.** Хөрөнгө оруулалтыг **ЗӨВХӨН НЭН ШААРДЛАГАТАЙ БАЙРШИЛД** хийнэ.

## Үдийн хоол хөтөлбөр 80.6 тэрбум₮

1 хүүхдийн өдрийн тариф **1500 төгрөг**

Хамрагдах хүүхдийн тоо **370 гаруй мянга**

ЕБС-ийн 1-5 ангийн хүүхдүүдэд үдийн хоолоор үйлчилнэ.

## Боловсролын байгууллагуудын бүтцийг оновчтой тогтоож, засаглалыг сайжруулна.

Боловсролын чанарын үнэлгээний бие даасан тогтолцоог сайжруулна.

## Боловсролын цахим шилжилт

-Онлайн сургалтын платформыг бий болгоно.
-Хичээлийн цахим сан бүрдүүлнэ.
-Сурагч сайн багшийн заасан хичээлийн онлайн контентод хандах боломжтой болно.

Боловсролын салбарын цахим шилжилтийн хүрээнд дээрх болон төрөл бүрийн бусад арга хэмжээг авна.

## МСҮТ тэтгэлэг

Хамрагдах суралцагчийн тоо **14.1 мянга**

МСҮТ суралцагчдын тэтгэлгийг төгсөхөд нь 1 удаа олгоно.

## Дээд боловсрол

### Боловсролын зээлийн сан

***Нийт: 79.4 тэрбум₮***

- Оюутны хөгжлийн зээл ---- 21.8 тэрбум₮
  - Гадаадад суралцагчдын зээл ---- 18.7 тэрбум₮
- Бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, 3 хүүхэд нь зэрэг суралцдаг өрхийн суралцагчдад олгох сургалтын төлбөрийн тэтгэлэг ---- 13.5 тэрбум₮
  - Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг ---- 4.9 тэрбум₮
- Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг ---- 3.4 тэрбум₮
  - Сувилагч мэргэжлээр төрийн өмчийн их дээд сургуульд суралцагсдын тэтгэлэг ---- 1.9 тэрбум₮
- Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох тэтгэлэг ---- 1.9 тэрбум₮
  - Багш мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд суралцаж байгаа суралцагчдын болон орон нутагт хийх багшлах дадлагын тэтгэлэг ---- 2.3 тэрбум₮
- Засгийн газрын гэрээгээр гадаадаас дотоодод суралцагчдад олгох тэтгэлэг ---- 0.6 тэрбум₮
  - Бусад ---- 10.4 тэрбум₮

# САЛБАРЫН ОНЦЛОГУУД

## БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСӨВ

Монгол улсын Их хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралт “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд дунд хугацаанд хүрсэн байх үр дүнгийн шалгуурыг дараах байдлаар заасан:

| | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин | Хүрэх түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 2025 | 2030 | 2050 |
| 1. | Хүний хөгжлийн үзүүлэлт | индекс | 0.74 | 0.77 | 0.85 | 0.90 |
| 2. | Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлт | индекс | 0.30 | 0.25 | 0.20 | 0.10 |
| 3. | Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин | хувь | 81.5 | 89.4 | 95.0 | 100.0 |
| 4. | Суурь боловсролын хамран сургалтын цэвэр жин | хувь | 94.9 | 95.9 | 96.8 | 100.0 |
| 5. | 7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших, тоо бодох) | хувь | 61.6<br>51.5 | 70.0 | 75.0 | 90.0 |
| 6. | Нийт төгсөгчдөд ажил эрхэлж байгаа төгсөгчдийн эзлэх хувь (МСҮТ, их, дээд сургууль) | хувь | 76.5 | 90.0 | 95.0 | 100.0 |
| 7. | Бүлэг дүүргэлт (боловсролын бүх түвшнээр) | тоо | Цэцэрлэг 33, ЕБС хотод 25, хөдөө 28. | 25-30 | 20-30 | 20-30 |

Монгол Улсын Засгийн газрын дээрх зорилт, салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлогын зорилтыг хангахын тулд дараах гурван чиглэлийн үзүүлэлтийг 2022 онд тооцохоор төлөвлөв. Үүнд:

- Сургалтын үр дүнгийн үзүүлэлт (Proficiency level)
- Элсэлтийг мөшгих үзүүлэлт (Cohort)
- Төгсөлтийн үзүүлэлт (Completion)

### Үр дүнгийн гүйцэтгэл болон хүрэх түвшин:

**Сургуулийн өмнөх боловсрол:**




**Бага боловсрол:**



## Ерөнхий боловсрол (дунд анги):




## Суурь боловсрол:




## Бүрэн дунд боловсрол:




## Ерөнхий боловсролын сургалтын орчин:




## Насан туршийн боловсрол:



# САЛБАРЫН ОНЦЛОГУУД

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГОТОЙ УЯЛДСАН ТӨСӨВ



Зохистой хөдөлмөр эрхлэлт ба эдийн засгийн өсөлтийг дэмжих ТХЗ-ын 8 дах зорилгыг Монгол улс амжилттай хэрэгжүүлж байна. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогуудыг уялдуулан төсвийн төсөлд тусгалаа.



Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, ур чадвар олгох, санхүүгийн дэмжлэг болон зээлд хамруулах, борлуулалтын дэмжлэг үзүүлэх, ажил олгогчийг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлснээр хөдөлмөр эрхлэлтийн шалгуур үзүүлэлтүүдийг сайжруулна.




### *Хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ:*

- “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”
- “Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”
- “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”
- “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”
- “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”

## АЛСЫН ХАРАА 2050-ИЙН ХҮРЭЭНД ТАВЬСАН ЗОРИЛТ БОЛОН АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

Хөдөлмөрийн зах зээлийн бодлого, үйл ажиллагаа, ажилгүйдлийн даатгалын эрх зүйн орчныг шинэчилж, ур дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлэх, ажилгүйдлээс сэргийлж ажлын байрыг хамгаална.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний уян хатан зохицуулалт бий болгож, эдийн засгийн болон хөдөлмөрийн зах зээлийн бодлоготой уялдуулна.

Хүн амын бүлгүүдэд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах, өндөр мэргэшил, ур чадварыг хөгжүүлэх, нутагшуулах бодлогоор хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг цахимжуулж, хүн амын бүлэг, эдийн засгийн салбарын онцлогт нийцүүлэн хөдөлмөрийн биржийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.




Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас иргэн, хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил бизнес эрхлэгчид олгох зээлийн хэмжээ, хугацааг нэмэгдүүлж, барьцаагүй, хүүгүй, эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн шинэ арга хэрэгслийг нэвтрүүлнэ.

# САЛБАРЫН ОНЦЛОГУУД
## ДЭД БҮТЭЦ, ХӨДӨӨ АЖ АХУЙ

**Татаас, урамшуулал**

| | |
|---|---|
| Эрчим хүчний татаас | **66.4** тэрбум₮ |
| Авто замын сан /замын засвар үйлчилгээ/ | **75.0** тэрбум₮ |
| Хөдөө аж ахуйн урамшуулал | **61.0** тэрбум₮ |

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2022 оны төсвийн төслийг Тогтвортой хөгжлийн зорилготой уялдуулан боловсруулсан. Үүнд дараах шалгуур үзүүлэлтүүдийг ирэх онд хангах зорилт тавилаа.

*Суурь түвшин* → *2022 оны зорилт*

### Мал аж ахуй

| Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 оны зорилт |
|---|---|---|
| Амьтны генетикийн нөөц /Үржүүлгийн бүтээгдэхүүн/-ий хэмжээ /мянган тун үр/ | 62.2 | 70.0 |
| Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн тоогоор | 2025 | 2318 |
| Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад давхардсан тоогоор нийт 24.8 сая толгой мэдрэмтгий мал сүргийг хамруулж, шүлхий өвчний гаралтыг бууруулах. Өвчний тохиолдлын тоо: | 20 | 18 |
| Бог малын мялзан өвчингүй тайван байдлыг хадгална /тохиолдлын тоо/ | 0 | 0 |

### Хүнсний үйлдвэрлэл

| Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 оны зорилт |
|---|---|---|
| Үйлдвэрт нийлүүлэх шингэн сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ /хувиар/ | 10.8 | 11.1 |

### Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх

| Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 оны зорилт |
|---|---|---|
| ЖДҮ, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх /шинээр бий болсон ажлын байрны тоо/ | 63177 | 97177 |

### Хөнгөн үйлдвэр

| Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 оны зорилт |
|---|---|---|
| Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтыг үргэлжлүүлэх /бүтээн байгуулалтын хувь/ | 23.0 | 60.0 |
| Арьс ширний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх /тэрбум төгрөг/ | 31.7 | 36.5 |
| Хөнгөн үйлдвэрийн салбарын бараа бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэх /сая ам.доллар/ | 489.4 | 513.9 |

### Газар тариалан

| Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2022 оны зорилт |
|---|---|---|
| Хөрсний үржил шим, буудайн чанарыг сайжруулж улаанбуудайн га-гийн ургацыг нэмэгдүүлнэ /цн/ | 14 | 15 |
| Буудайн элит үрийн нөөц бүрдүүлэн үрийн шинэчлэл хийнэ /мян.га/ | 2450 | 1500 |
| Усалгаатай тариалангийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ /мян.га/ | 61.0 | 63.0 |
| Хүнсний ногооны хангамжийн хувь | 56.0 | 60.0 |

# САЛБАРЫН ОНЦЛОГУУД
## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ



Монгол Улсын Засгийн газрын зүгээс урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050" болон Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээлэн буй орчин, байгаль хамгааллын салбарт хамаарах дараах зорилгуудтай уялдсан төсөвлөлт хийж байна.

**2020**

Цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах, хамгаалалтын зурвас байгуулах арга хэмжээг **45 га** талбайд хэрэгжүүлэхээс **35 га**-д амжилттай хэрэгжүүлсэн.

**2021**

Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний **1 га** талбайн зардлын нормативыг **2-5 дахин** нэмэгдүүлэн шинэчилж, говь, цөлийн бүсэд ойжуулалтын усалгааны асуудлыг бүрэн шийдвэрлэснээр ургалтын чанар, тоо хэмжээ нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн

**2022**

**"Тэрбум мод"**
үндсэний хөдөлгөөн
**12.1**
**тэрбум ₮**

